



ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БУЮУ ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Засаглалын бодлого” хэмээх Дөрөвдүгээр бүлгийн 4.1.2-т “Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх” гэж, 4.1.6-д “Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхийг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Засаглалын бодлого” хэмээх Тавдугаар бүлгийн зорилгыг цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжих гэж тодорхойлсон бөгөөд тус баримт бичгийн Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем) хэсгийн зорилтыг тодорхойлоходо хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэхээр, уг зорилтын хүрээнд 2021-2030 оныг мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлэх үе байхаар тогтоосон.

2. Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй байх, хувь хүний нууцтай байх, үүнийг хуулиар тогтоон хамгаалахаар заасны дагуу Улсын Их Хурал 1995 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Хувь хүний нууцын тухай хуулийг баталж, мөн оныхоо 7 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөгджэх эхэлсэн бөгөөд хувь хүний нууцыг хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулж байгаа суурь эрх зүйн зохицуулалт юм.

Энэ хууль нь 3 бүлэг, 9 зүйлээс бүрдэх бөгөөд хэрэгжиж эхэлснээс хойш уг хуульд 2 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Тус хуулиар “Хувь хүний нууц” гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг

сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ хэмээн тодорхойлсон ба хувь хүний нууцыг 5 төрөлд ангилсан.

Эдгээрт захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүл, хуулиар тогтоосон бусад нууцыг хамааруулахаар зааж, хувь хүн нууцаа өөрөө хамгаалах, хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглох, шаардлагатай тохиолдолд хувь хүний нууцыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага хамгаалалтдаа авч болохоор заасан. Мөн хувь хүний нууцыг ил болгох үндэслэл, энэ хуулиар хамгаалсан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрх болон хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулахад томоохон хувь нэмэр оруулсан хэдий ч нийгмийн харилцаа тасралтгүй хөгжиж байгаа технологийн хөгжлийг дэмжсэн энэ цаг үед нийгэмд үүсээд байгаа зарим төрлийн асуудлыг Хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулахад бэрхшээлтэй нөхцөл байдлууд үүссээр байгааг дурдах нь зүйтэй.

Тухайлбал, Хувь хүний нууцын тухай хуулиар хувь хүний нууцыг хязгаарлагдмал хүрээнд тогтоож, зөвхөн эрүүл мэнд, захидал харилцаа, хөрөнгө, гэр бүлийн нууцыг хувь хүний нууцад хамааруулахаар зааж, хувь хүнийг тодорхойлох боломжтой бусад мэдээллийг хэрхэх талаар энэ хуульд тусгаагүй, мөн хувь хүн нууцаа зөвхөн өөрөө хамгаалахаар заасан нь хүний хувийн мэдээллийг хариуцаж байгаа этгээд үүрэг хүлээж байгаа олон улсын жишиг зохицуулалттай нийцээгүй, мөн хуулиар хувь хүний нууцыг задруулснаар тухайн хүнд “илтэд хохирол учруулж болзошгүй” гэх хэт өндөр стандартыг тогтоож хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөд түүнийг хамгаалах боломжгүйд хүрэх зэргийг дурдаж болохоор байна.

Сүүлийн жилүүдэд үйлчилгээний газруудад хэрэглэгчийн худалдан авалтын үнийн дунд суурилсан оноо цуглуулах, хувь хүнийг таньж баталгаажуулах зорилгоор хүний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/ болон хувь хүний бусад мэдээлэл цуглуулах нь түгээмэл байгаа бөгөөд ингэхдээ хүний хувийн мэдээллийг тухайн хувь хүнд урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авалгүйгээр цуглуулах, анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор ашиглах, зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах, хүний хувийн мэдээлэл алдагдах эрсдэл үүссэн тохиолдолд эргэн мэдэгдэх, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах зэрэг асуудал үүсэхэд Хувь хүний нууцын тухай хуулийг хэрэглэхэд зохицуулалтын агуулга нь хэт ерөнхий, тунхаглалын шинжтэй, тодорхой төрлийн асуудлыг шийдвэрлэж чадахгүйд хүргэж байна.

Түүнчлэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж ашиглан хүний хувийн мэдээлэл цуглуулах, хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд сэргэөр нөлөөлөх мэдээллийг олон нийтэд түүний зөвшөөрөлгүйгээр ил болгох, бусдад дамжуулах үйлдлийд ихээхэн нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь дүрс бичлэгийн төхөөрөмжийг байршуулж болох тохиолдлуудыг хуулиар нарийвчлан заагаагүй, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлоогүй, хориглох зохицуулалт байхгүй, хяналт тавьдаггүй зэрэгтэй холбоотой гэж үзэж байна.

Мөн Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай зэрэг хуулиар хүний хувийн мэдээллийг хадгалах, хамгаалах, нууцлах, зөвшөөрөл авах, нийтлэх, тараах, хариуцлага хүлээлгэх зэрэг зарим харилцааг зохицуулж байгаа боловч хүний хувийн мэдээлэл цуглуулах, бүртгэх, хадгалах, дамжуулах, ашиглах, өөрчлөх, устгах зэрэг мэдээлэл боловсруулалтын үйл ажиллагаа явуулахад мэдээллийн эзэн болон хүний хувийн мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа этгээд хоорондын эрх зүйн харилцааг тусгайллан зохицуулсан хууль байхгүй, эрх олгосон, зөвшөөрсөн, хориглосон үйлдлийг нарийвчлан зохицуулаагүй байдал нь иргэдэд ойлгомжгүй байдал үүсгэж, Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөд хүргэж болзошгүй байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад заасны дагуу хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаагаар хүний хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой харилцааг бие даасан хуулиар зохицуулах зайлшгүй шаардлагатай тухай зөвлөмж гарсан бөгөөд олон улсын туршлагаас үзэхэд дэлхийн 193 улс орноос 45.6 хувь буюу 88 улс орон хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлж байна.

Дээрх судалгааны хүрээнд Америкийн Нэгдсэн Улс, Эстони Улс, Словенъ Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Тайвань зэрэг 10 гаруй улс орнуудын хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулиудыг харьцуулан судалж үзэхэд Европын холбоонд хүчин төгөлдөр мөрдөгдөх буй “Хувь хүний мэдээлэл хамгаалах ерөнхий хууль”-ийг жишиг болгон Хувь хүний нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулах нь зйтэй гэж үзэж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэг буюу нийтлэг үндэслэлд хуулийн төслийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлж, хуульд хэрэглэсэн нэр томьёоны тодорхойлолт, хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад баримтлах зарчмыг тусгана. Хуулийн төсөлд хүний хувийн мэдээлэл, эмзэг мэдээлэлд юг хамааруулах, хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хүний хувийн мэдээлэл хариуцагч /controller/, хүний хувийн мэдээлэл боловсруулагч /processor/, генетикийн болон биометрик мэдээлэл зэрэг нэр томьёог бусад улс орны жишигт тулгуурлан тодорхойлно.

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт хүний хувийн мэдээлэл цуглуулахад мэдээллийн эznээс зөвшөөрөл авах, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглаж болох үндэслэлийг тогтооно. Мөн хүний эмзэг мэдээлэл, биометрик мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах нөхцөл болон түүхийн болон шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний зорилгоор мэдээлэл боловсруулах, ашиглах зохицуулалтыг тусгана.

Түүнчлэн мэдээллийн эзэн нас барсан тохиолдолд тухайн хүний хувийн мэдээллийг хэрхэх талаар хуулийн төсөлд холбогдох журмыг оруулна.

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад мэдээллийн эзний эдэлж болох эрх, хүлээх үүргийг тогтооно.

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт мэдээлэл хариуцагчийн мэдээллийн эзний өмнө хүлээх үүрэг, мэдээлэл хариуцагч гэрээний үндсэн дээр мэдээлэл цуглуулах, боловсруулах үүргийг мэдээлэл боловсруулагчид шилжүүлсэн тохиолдолд мэдээлэл боловсруулагчийн хүлээх үүргийг тусгана.

Хуулийн төслийн тавдугаар бүлэгт хүний хувийн мэдээлэл хамгаалах талаар аюулгүй байдлын арга хэмжээ авах, мэдээллийн эзэнд мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотой мэдэгдэл өгөх тохиолдол, зөрчлийг мэдэгдэх, нөлөөллийн үнэлгээ хийх талаар оруулна.

Хуулийн төслийн зургаадугаар бүлэгт Хүний хувийн мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллагыг тогтоож, энэ хуулийн хэрэгжилтийг хянаж ажиллах чиг үүргийг тодорхой болгон, Хүний эрхийн Үндэсний Комисс Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон төрийн бусад байгууллага мэдээлэл хариуцагчийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд хяналт тавихаар тусгана.

Хуулийн төслийн долоодугаар бүлэгт дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмжийг байршуулах тохиолдол, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн системд тавигдах шаардлага, хориглох, хяналт тавих зохицуулалтыг тусгана.

Хуулийн төслийн наймдугаар бүлэгт мэдээллийн эзний гомдлыг шийдвэрлэх, хүний хувийн мэдээлэл боловсруулах, хамгаалах талаар хориглох зүйл, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагататай холбоотой бусад зүйлийг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах үр дагавар гарна:

1.Хүний хувийн мэдээлэл хамгаалах эрх зүйн орчин бүрдэж, хувь хүн буюу мэдээллийн эznээс түүний мэдээллийг цуглуулах, боловсруулах талаар зөвшөөрөл авах тогтолцоо бүрдэнэ;

2.Хувь хүн буюу мэдээллийн эзэн, хүний хувийн мэдээлэл хариуцагч болон боловсруулагчийн эрх, үүргийг тогтоосноор хүний хувийн мэдээллийг анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор ашиглахад хязгаар тогтоох, хүний хувийн мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлж, хүний эрхийн баталгаа дээшилнэ;

3.Хүний хувийн мэдээлэл боловсруулах, хамгаалах талаар хориглох зүйлийг тогтоож, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй уялдуулан Хувь хүний нууцын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, хүний хувийн мэдээлэл боловсруулах, хамгаалах талаар тогтоосон эрх зүйн зохицуулалтыг зөрчсөний улмаас иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох чиглэлээр Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль болон хуулийн нэршлийг өөрчилж байгаатай уялдуулан холбогдох бусад хуулиудад өөрчлөлт оруулна.

---00---